МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/189 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын улирал эхэлж гол, мөрөн, нуурын ус гэсэж байгаатай холбогдуулан үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар	(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ё.Пүрэвсүрэн	(Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
Т.Ганхуяг	(Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа)
П.Мөнхжаргал	(Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга)
Т.Олонбаяр	(Монгол Улсын Далайн захиргааны Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн)
Г.Энхбаяр	(Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
И.Найманжин	(Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргааны дарга)
Ш.Түмэнбаяр	(Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын Хамгаалалтын захиргааны дарга)
Г.Адъяасүрэн	(Хөвсгөл аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Х.Даваасүрэн (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:
Ё.Ариунзаяа (Мэргэжлийн хяналтын газрын Усан замын хяналтын улсын байцаагч)

1. Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, холбогдох төлөвлөгөө гарган үйл явцыг тухай бүр танилцуулан хэрэгжүүлж ажиллахыг Ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

2. Харьяалагдах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээллийг мэргэжлийн байгууллагатай хамтран иргэдэд түгээх, эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, Тосгоны захирагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН